



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2020.05 сар














bayanzurkh@nso.mn



page: Баянзүрх дүүргийн
статистикийн хэлтэс

АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2
 НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ	3
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ	5
 ЭРҮҮЛ МЭНД	7
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	9
 ГЭМТ ХЭРЭГ	10
 ДҮҮРГИЙН ТӨСӨВ	13
 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	16
 АЖ ҮЙЛДВЭР	19
 ХӨДӨӨ АЖ АХУЙ	22

Хүснэгт 1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлт, жил бүрийн эхний V сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017	2018	2019	2020
Суурин хүн ам	мянган хүн	327.1 ^{↑1.9}	336.9 ^{↑3.0}	*343.6 ^{↑2.0}	*361.5 ^{↑5.2}
Нийт өрхийн тоо	мянган өрх	93.7 ^{↑0.6}	95.0 ^{↑1.4}	*96.0 ^{↑1.1}	*104.7 ^{↑9.0}
Шинээр төрсөн хүүхэд	тоо	3 013 ^{↓7.9}	3 191 ^{↑5.1}	3 283 ^{↑2.9}	3 275 ^{↓0.2}
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	3 812 ^{↓42.4}	4 446 ^{↑16.6}	2 976 ^{↓33.1}	1 576
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	1 739 ^{↑11.2}	4 084 ^{↑134.8}	2 670 ^{↓34.6}	2 082 ^{↓47}
Хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт	хувь	0.6 ^{↑500}	0.2 ^{↓66.7}	1.4 ^{↑600}	-0.1 ^{↓107}
Валютын зах зээлийн ханш	1 US\$=Төгрөг	2 397 ^{↑20.5}	2 412 ^{↑0.6}	2 651 ^{↑9.9}	2 796 ^{↑5.5}
Дүүргийн төсвийн орлого	тэрбум төгрөг	40.8 ^{↑11.8}	46.2 ^{↑13.2}	55.1 ^{↑19.3}	76.3 ^{↑38.5}
Дүүргийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	35.1 ^{↑12.7}	40.2 ^{↑14.6}	47.4 ^{↑17.9}	72.2 ^{↑52.3}

Тайлбар: Өмнөх онтой харьцуулсан

↑, ↓ эерэг өөрчлөлтийн хувь;
 ↑, ↓ сөрөг өөрчлөлтийн хувь;
 = тогтвортой

* 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хүн ам, өрхийн тоо

Хүснэгт 2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих Нэгж	2019 оны V сард				2020 оны V сард					
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	309	Баянгол	7 755	Налайх	55	315	Баянгол	7 699	Налайх	55
			Чингэлтэй	1 774	Багануур	48		Чингэлтэй	1 704	Багануур	46
			Сүхбаатар	701	Багахангай	31		Сүхбаатар	702	Багахангай	30
Ажилгүйчүүд хөдөлмөрийн насны 10 000 хүнд ногдох	0\000**	84	Багахангай	453	Баянгол	78	65	Багахангай	568	Хан-Уул	60
			Багануур	146	Хан-Уул	57		Багануур	121	Баянзүрх	52
			Сүхбаатар	113	Сонгинохайрхан	46		Баянгол	95	Сонгинохайрхан	37
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	13	Налайх	20	Баянгол	7	11	Сонгинохайрхан	12	Налайх	8
			Чингэлтэй	14	Хан-Уул	6		Чингэлтэй	9	Сүхбаатар	4
			Баянзүрх	13	Багахангай	-		Баянгол	9	Багахангай	-
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	71	Баянзүрх	88	Баянгол	55	50	Сонгинохайрхан	46	Сүхбаатар	29
			Хан-Уул	63	Багануур	52		Багануур	46	Хан-Уул	26
			Чингэлтэй	59	Багахангай	7		Баянзүрх	45	Багахангай	9
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	84	Сүхбаатар	104	Налайх	14	71	Сүхбаатар	61	Багануур	10
			Чингэлтэй	60	Багануур	11		Чингэлтэй	59	Налайх	9
			Хан-Уул	50	Багахангай	7		Хан-Уул	41	Багахангай	8
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	114	Сүхбаатар	171	Налайх	65	81	Сүхбаатар	133	Багахангай	57
			Чингэлтэй	130	Багануур	51		Баянгол	96	Налайх	56
			Баянгол	128	Багахангай	35		Баянзүрх	86	Багануур	39

Тайлбар: * - промилль ** - процицми



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 2020 оны 5 дугаар сард 859 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 1458 хүнээр (63.0%) буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 433 (50.4%) нь эмэгтэйчүүд байна.


Хүснэгт 3. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2018 V	2019 V	2020 V	2018 V	2019 V	2020 V
Ажилгүйчүүд, бүгд	2 616	2 317	859	100.0	100.0	100.0
Үүнээс: Магистр, доктор	20	15	6	0.8	0.6	0.7
Дипломын болон бакалавр	1 080	1 113	153	41.3	48.0	17.8
Тусгай мэргэжлийн дунд	95	63	25	3.6	2.7	2.9
Техникийн болон мэргэжлийн	56	45	14	2.1	1.9	1.6
Бүрэн дунд боловсролтой	1 297	1 044	640	49.6	45.0	74.5
Суурь боловсролтой	41	23	8	1.6	1.0	0.9
Бага боловсролтой	14	4	1	0.5	0.3	0.2
Боловсролгүй	13	10	12	0.5	0.5	1.4

Эх үүсвэр: Дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн мэдээлэл

Хөдөлмөрийн хэлтэст 5 дугаар сард 9 хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгүүлсэн бөгөөд эдгээрийн 4 нь эмэгтэйчүүд байна.

Зураг 1. Бүртгэлтэй ажилгүйчүүд, насны бүлэг, 2020 оны V сарын эцэст





НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

2020 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангийн орлого 60.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 11.8 тэрбум төгрөгөөр (16.3%) буурсан байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогын 64.4 хувийг тэтгэврийн даатгалын сангийн, 19.6 хувийг эрүүл мэндийн даатгал, 8.1 хувийг тэтгэмжийн даатгал, 6.3 хувийг ҮОМШӨ¹-ний даатгал, 1.6 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого тус тус бүрдүүлсэн байна.

Хүснэгт 4. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, сая төгрөг

Үзүүлэлт	2019 I-V	2020 I-V	Зөрүү	Өсөлт, бууралт	Дүнд эзлэх хувь
Нийгмийн даатгалын сангийн дүн	72.5	60.7	11.8	-16.3	100.0
Тэтгэврийн даатгалын сан	46.8	39.1	7.7	-16.5	64.4
Эрүүл мэндийн даатгалын сангийн сан	14.1	11.9	2.2	-15.6	19.6
Тэтгэмжийн даатгалын сан	6.0	4.9	1.1	-18.3	8.1
ҮОМШӨ-ний даатгалын сан	4.5	3.8	0.7	-15.5	6.3
Ажилгүйдлийн даатгалын сан	1.1	1.0	0.1	-9.1	1.6

Хүснэгт 5. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага, сая төгрөг


Үзүүлэлт	Төлөвлөгөө 2020 I-V	Гүйцэтгэл 2020 I-V	Хэтрэлт (+) Хэмнэлт (-)
Нийгмийн даатгалын сангийн дүн	102.8	100.5	-2.3
Тэтгэврийн даатгалын сан	91.4	89.6	-1.8
Эрүүл мэндийн даатгалын сан	-	-	-
Тэтгэмжийн даатгалын сан	6.1	5.8	-0.3
ҮОМШӨ-ний даатгалын сан	0.8	0.9	0.1
Ажилгүйдлийн даатгалын сан	4.5	4.2	-0.3

Эх үүсвэр: Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээлэл

2020 оны эхний 05 сард нийгмийн даатгалын сангийн зарлага 102.8 тэрбум төгрөг төлөвлөснөөс 2.3 тэрбум төгрөгөөр дутуу буюу 100.5 тэрбум төгрөг зарцуулсан байна.

¹ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

Зураг 2. Нийгмийн даатгалын сангийн зарлага, эзлэх хувь, төрлөөр



Нийгмийн халамж: 2020 оны 5 дугаар сард нийгмийн халамжийн сангийн нийт зарлагын 54.1 хувь нь халамжийн тэтгэврийн санд, 17.0 хувь нь нөхцөлт мөнгөн тусламжид, 5.5 хувь нь ахмад настны хөнгөлөлтөд, 4.3 хувь нь жирэмсэн болон хөхүүл, нярай хүүхэдтэй эхэд олгох тэтгэмжид, 1.7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд, 0.9 хувь нь алдарт эхийн одон, 2.4 хувь нь алдар цолтон ахмад настнуудад олгосон тусламж, хөнгөлөлт, 14.1 хувь нь хүнс тэжээлийн хөтөлбөрийн зардал, амьжиргааг дэмжих зөвлөлд, 0.1 хувь нь насны хишгийн зардалд тус тус зарцуулагдсан байна.

Хүснэгт 6. Нийгмийн халамжийн орлого, зарцуулалт

Үзүүлэлт	Хүний тоо			Мөнгөн дүн, сая төгрөг		
	2018 V	2019 V	2020 V	2018 V	2019 V	2020 V
Халамжийн сангийн орлого	29 111	31 000	32 100	1 811.0	1 900.0	2 400.0
Зарлагын нийт дүн	37 482	32 889	23 159	1 729.0	2 057.0	2 389.6
Халамжийн тэтгэвэр	4 439	5 516	4 613	672.0	939.0	1 292.5
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	3 576	4 912	4 578	245.0	356.0	406.1
Ахмад настны хөнгөлөлт	1 620	1 931	814	264.0	336.0	132.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох тэтгэмж	534	609	513	55.0	48.0	39.8
Жирэмсэн болон хөхүүл, нярай хүүхэдтэй эхэд олгох тэтгэмж	3 313	3 111	2 810	127.0	116.0	103.9
Алдарт эхийн одонгийн тусламж	210	187	184	25.0	22.0	20.5
Алдар цолтон ахмад настнуудад олгосон тусламж, хөнгөлөлт	387	292	357	59.0	48.0	56.4
Хүнс тэжээлийн хөтөлбөрийн зардал	23 358	16 294	9 264	280.0	190.0	335.8
Амьжиргааг дэмжих зөвлөл	-	-	-	-	-	-
Насны хишгийн зардал	45	37	26	3.0	3.0	2.0




ЭРҮҮЛ МЭНД

2020 онд 5 сард дүүргийн эмнэлэгт 3275 хүүхэд төрсөн нь 2019 оны мөн үетэй харьцуулахад 8 хүүхдээр (0.2%) буурсан үзүүлэлттэй байна. Нас баралт 541 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 25 хүнээр (4.4%)


буурсан байна.

Халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 1576 болж өмнөх оны мөн үеэс 1400 хүнээр (47.0%) буурсан байна.

Зураг 3. Халдварт өвчин, 10000 хүнд ногдох



Зураг 4. Бэлгийн замын халдварт өвчний тоо



Хүснэгт 7. Эрүүл мэндийн зарим үзүүлэлт, жилээр

Үзүүлэлт	2016 V	2017 V	2018 V	2019 V	2020 V
Шинээр төрсөн хүүхэд	3 273	3 013	3 191	3 283	3 275
Эхийн эндэгдэл	2	-	2	-	2
100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл	61.1	-	62.7	-	61.1
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	76	47	26	42	29
Амьд төрсөн 1 000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	23.2	15.6	8.1	12.8	8.9
1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл	14	6	5	7	3
Амьд төрсөн 1 000 хүүхэд тутмаас 5 хүртэл насанд эндсэн хүүхэд	4.3	2.0	1.6	2.1	0.9
Нас баралт	579	536	560	566	541
Халдварт өвчнөөр өвчлөгчид	6 617	3 812	4 446	2 976	1 576
10 000 хүн ам тутамд ногдох халдварт өвчин	210.2	117,7	133.9	87.5	47.0

Баянзүрх дүүргийн хэмжээнд 2019 оны 5 сард 10000 хүн амд ногдох халдварт өвчний тоо 87.5 байсан бол энэ онд 44.7 байгаа нь өмнөх оны мөн үеэс 42.8 хувиар буурсан байна. Бэлгийн замын халдварт өвчин 2020 оны 5 сард тэмбүү 339, заг хүйтэн 68, трихомониаз 196 тус тус бүртгэгдсэн.

Хүснэгт 8. Дүүргийн хэмжээнд гарсан халдварт өвчин, жилээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 V	2018 V	2019 V	2020 V
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд	бодит тоо	3 812	4 446	2 976	1 576
	10000 хүнд	117.7	133.9	87.5	44.7
Үүнээс:					
Вируст гепатит	бодит тоо	35	27	20	18
	10000 хүнд	1.1	0.8	0.6	0.5
Менингит	бодит тоо	-	3	4	-
	10000 хүнд	-	0.1	0.1	-
Цусан суулга	бодит тоо	185	296	360	140
	10000 хүнд	5.7	8,9	10.6	4.0
Салхин цэцэг	бодит тоо	1258	740	1 189	378
	10000 хүнд	38.8	22.3	34.9	10.7
Гахай хавдар	бодит тоо	18	35	4	3
	10000 хүнд	0.6	1.1	0.1	0.1
Сальмонеллэз	бодит тоо	18	72	27	23
	10000 хүнд	0.6	2.2	0.8	0.7
Улаан эсэргэнэ	бодит тоо	297	149	132	22
	10000 хүнд	9.2	4.5	3.9	0.6
Хоолны хордлого	бодит тоо	16	13	128	4
	10000 хүнд	0.5	0.4	3.8	0.1
Ёлом	бодит тоо	21	6	11	5
	10000 хүнд	0.6	0.2	0.3	0.1
Бруцеллэз	бодит тоо	4	2	3	1
	10000 хүнд	0.1	0.1	0.1	0.0
Нярайн халдвар	бодит тоо	-	-	1	-
	10000 хүнд	-	-	0.03	-
Гар хөл амны өвчин	бодит тоо	979	337	266	50
	10000 хүнд	30.2	10.1	7.8	1.4
Тэмбүү	бодит тоо	238	245	248	339
	10000 хүнд	7.3	7.4	7.3	9.6
Заг хүйтэн	бодит тоо	95	91	76	68
	10000 хүнд	2.9	2.7	2.2	1.9
Трихомониаз	бодит тоо	169	177	202	196
	10000 хүнд	5.2	5.3	5.9	5.6
Шинээр илэрсэн сүрьеэ	бодит тоо	278	220	294	282
	10000 хүнд	8.6	6.6	8.6	8.0
Бусад	бодит тоо	201	2 033	11	4

Эх үүсвэр: Нийслэлийн Эрүүл мэндийн газрын сар бүрийн мэдээлэл



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж хэм 2020 оны 5 дугаар сард дунджаар 10.5⁰С байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.2⁰С-аар дулаан байв. Энэ сарын хамгийн дулаан хэм 26.9⁰С, хамгийн хүйтэн хэм -2.3⁰С, хүр тунадасны нийлбэр 11.8 мм, шороон болон цасан шуургатай өдөр 6 бүртгэгдсэн байна.

Хүснэгт 9. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, V сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Ургах наран хороолол	Офицеруудын ордон	Амгалан
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	0.004	0.003	-
	Хамгийн их	0.011	0.012	-
	XXX*-с давсан хувь	0.0	0.0	-
	Хэмжилтийн тоо	31	30	-
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	-	0.038	0.021
	Хамгийн их	-	0.071	0.033
	XXX*-с давсан хувь	-	13.0	-
	Хэмжилтийн тоо	-	30	31
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	0.484	-	-
	Хамгийн их	1.289	-	-
	XXX*-с давсан хувь	0	-	-
	Хэмжилтийн тоо	93	-	-
Тоос PM ₁₀	Дундаж	-	-	0.082
	Хамгийн их	-	-	0.207
	XXX*-с давсан хувь	0.0	0.0	26.0
	Хэмжилтийн тоо	-	-	31
Тоос PM _{2.5}	Дундаж	-	-	0.016
	Хамгийн их	-	-	0.033
	XXX*-с давсан хувь	-	-	0.0
	Хэмжилтийн тоо	-	-	31
Озон O ₃ **	Дундаж	-	-	-
	Хамгийн их	-	-	-
	XXX*-с давсан хувь	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	-	-

* - Хүлцэх хэм хэмжээ,

** - CO, O₃-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон.



ГЭМТ ХЭРЭГ


2020 оны эхний 5 сард дүүргийн нутаг дэвсгэрт 2 082 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 588 хэргээр (22.0%) буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 10. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, төрлөөр, эхний 5 сард

Төрөл	2019	2020	Үүнээс: Цагдаагийн хэлтсээр			Өсөлт, бууралт	
			I	II	III	Тоо	Хувь
Нийт	2 670	2 082	875	666	541	-588	-22.0
Үүнээс:							
Учрал	40	16	5	4	7	-24	-60
Хүний амь	10	11	4	3	4	1	10
Хүчин	28	24	7	7	10	-4	-14.3
Дээрэм	114	63	21	32	10	-51	-44.7
Өмчийн хулгай	897	767	362	195	210	-130	-14.5
Булаалт	-	-	-	-	-	-	-
Залилан	556	398	153	165	80	-158	-28.4
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	685	565	215	169	181	-120	-17.5
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	33	34	10	17	7	1	3.0
Танхайрах	-	-	-	-	-	-	-
Бусад	307	204	98	74	32	-103	-33.6

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 36.8 хувийг өмчийн хулгайн гэмт хэрэг эзэлж байгаа бол 27.1 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 19.1 хувийг залилан, 3.0 хувийг дээрэм, 1.6 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, 0.8 хувийг золгүй учрал, ашиглалтын журмын эсрэг хэрэг 9.8 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

Зураг 5. Бүртгэгдсэн гэмт хэрэг, илрүүлэлт, дүүргээр



Хүснэгт 11. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Дүүрэг	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг			Өсөлт, бууралт 2019-2020	
	2018 V	2019 V	2020 V	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	13 383	10 740	7 922	-2 818	-26.2
Баянзүрх	4 084	2 670	2 082	-588	-22.0
Үүнээс: Цагдаагийн хэлтсээр					
I хэлтэс	1 400	949	875	-74	-7.8
II хэлтэс	1 797	1 131	666	-465	-41.1
III хэлтэс	887	590	541	-49	-8.3
Нийслэлийн дүнд эзлэх хувь	30.5	24.9	26.3	1.4	5.6

Дүүргийн хэмжээнд 2020 оны 5 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн нийслэлийн дүнд эзлэх хувийн жин 26.3 байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.4 пунктээр нэмэгдсэн байна. Түүнчлэн дүүргийн хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 42.0 хувь нь цагдаагийн I хэлтсийн харьяа хороодын нутаг дэвсгэрт үйлдэгджээ.

Хүснэгт 12. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо

Дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс:	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
		Сэжигтнийг илрүүлж ял сонсгосон	
Нийслэлийн дүн	6 269	2 050	32.7
Баянзүрх	1 588	488	30.7
Үүнээс: Цагдаагийн хэлтсээр			
I хэлтэс	675	220	32.6
II хэлтэс	509	155	30.5
III хэлтэс	404	113	28.0
Нийслэлийн дүнд эзлэх хувь	25.3	23.8	1.5

Дүүргийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь 30.7 байгаа нь нийслэлийн дунджаас 2.0 пунктээр доогуур байна.

Гэмт хэргийн улмаас 1 575 хүн гэмтэж осолдон, 27 хүн нас барж, төр ард иргэдэд 7 766.1 сая төгрөгийн хохирол учруулсны 1 379.3 сая (17.8%) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

2020 оны эхний 4 сард тус дүүргийн хамгийн их хүн ам суурьшсан бүс болох 14 дүгээр хороонд 192 гэмт хэрэг гарч хамгийн өндөр байхад харин тус дүүргээс 28 дугаар хорооны нутаг дэвсгэрт 19 гэмт хэрэг гарсан нь хамгийн бага байна.

Эх үүсвэр: Цагдаагийн нэг, хоёр, гуравдугаар хэлтсийн сар бүрийн мэдээлэл




ДҮҮРГИЙН ТӨСӨВ

2020 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээр дүүргийн төсвийн орлого 76.2 тэрбум төгрөг, төсвийн зарлага 72.2 тэрбум төгрөг болж, төсвийн тэнцэл 4.0 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Хүснэгт 13. Дүүргийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн эхний 5 сард


Үзүүлэлт	2017 V	2018 V	2019 V	2020 V
	сая төгрөг			
Төсвийн орлого	40 826.9	46 212.0	55 125.5	76 288.8
Төсвийн зарлага	35 076.1	40 205.9	47 420.2	72 234.1
Төсвийн орлого, зарлагын зөрүү	5 750.8	6 006.1	7 705.3	4 054.7

Зураг 6. Төсвийн нийт орлого, зарлага, сая төгрөг



Төсвийн орлого: 2020 оны эхний 5 сарын төсвийн гүйцэтгэлийн урьдчилсан мэдээгээр нийт дүүргийн төсвийн орлогын 60.7 тэрбум төгрөгийг (79.6%) тусламжийн орлого буюу улсын төсвийн санхүүжилт, 14.9 тэрбум төгрөгийг (19.5%) татварын орлого, 0.6 тэрбум төгрөгийг (0.9%) татварын бус орлого тус тус эзэлж байна. Төсвийн орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс 19.8 тэрбум төгрөгөөр (20.7%) дутуу бүрдсэн байна. Үүнд татварын орлого 9.0 тэрбум төгрөгөөр (37.8%) дутуу бүрдсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Зураг 7. Төсвийн орлого, сая төгрөг



Хүснэгт 14. Төсвийн орлогын гүйцэтгэл, сая төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%	Зөрүү
Нийт орлогын дүн	96 169.2	76 288.8	79.3	-19 880.4
Тусламжийн орлого ²	71 770.8	60 717.8	84.6	-11 053.0
Тусгай зориулалттай шилжүүлгээс	71 300.0	60 494.8	84.8	-10 805.2
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан	470.8	223.0	47.4	-247.8
Орон нутгийн төсвөөс санхүүжих ¹	24 398.4	15 571.0	63.8	-8 827.4
Татварын орлого	23 991.1	14 918.1	62.2	-9 073.0
Татварын бус орлого	407.3	652.9	160.3	-245.6

Хүснэгт 15. Татварын орлогын бүрдүүлэлт, сая төгрөг

Үзүүлэлт	2020 он			
	Нийт төсөв	Өссөн дүн (эхний V сард)		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувийн жин
Татварын орлого	48 676.4	23 991.1	14 918.1	62.2
Орлогын албан татвар	29 470.7	14 573.4	11 255.8	77.2
Хувь хүний орлогын албан татвар	29 470.7	14 573.4	11 255.8	77.2
Үйл ажиллагааны орлого	3 610.7	1 577.0	3 059.7	194.0
Хөрөнгийн орлого	15 700.0	8 022.8	5 534.3	69.0
Хөрөнгө борлуулсны орлого	4 100.0	1 928.3	470.5	24.4
Шууд бус орлого	6 060.0	3 045.3	2 191.3	72.0
Хөрөнгийн албан татвар	115.7	38.6	34.0	88.1
Бууны албан татвар	115.7	38.6	34.0	88.1
Бусад татвар, төлбөр, хураамж	19 090.0	9 379.1	3 628.3	38.7
Улсын тэмдэгтийн хураамж	3 400.0	1 561.6	1 566.0	100.3
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4 290.0	1 953.5	1 378.8	70.6
Газрын төлбөр	11 400.0	5 864.0	683.5	11.7

Төсвийн зарлага: 2020 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлийн мэдээгээр дүүргийн төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 73.1 хувийг (72.2 тэрбум төгрөг) санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 26.9 хувийг (26.5 тэрбум төгрөг) төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

¹ Орон нутгийн төсвөөс санхүүжих дүнд урьд оны үлдэгдлээс санхүүжих дүн ороогүй.

² Тусгай зориулалттай шилжүүлэгийн орлогод төсвөөс санхүүжих дүн, хандив тусламжийн орлогыг оруулсан.


Хүснэгт 16. Төсвийн зарлагын гүйцэтгэл, сая төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%	Зөрүү
Нийт зардлын дүн	98 774.0	72 234.1	73.1	-26 539.9
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	33 708.4	26 877.0	79.7	-6 831.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4 139.5	3 108.9	75.1	-1 030.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4 333.6	2 833.1	65.4	-1 500.5
Хангамж бараа материалын зардал	4 323.8	3 957.4	91.5	-366.4
Нормативт зардал	3 205.0	3 112.5	97.1	-92.5
Эд, хогшил урсгал засварын зардал	880.1	716.4	81.4	-163.7
Томилолт зочны зардал	17.0	17.0	100.0	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	2 476.9	1 793.3	72.4	-683.6
Бараа үйлчилгээний бусад зардал	4 404.1	3 793.7	86.1	-610.4
Татаас	7 600.0	5 517.0	72.6	-2 083.0
Урсгал шилжүүлэг	28 226.7	18 166.7	64.3	-10 060.0
Хөрөнгийн зардал	5 458.9	2 341.1	42.9	-3 117.8

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн сарын мэдээ

Төсвийн зарлагыг бүтцээр нь авч үзвэл 37.2 хувийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, 4.3 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалын санд төлөх шимтгэл, 7.7 хувийг татаас, 25.1 хувийг урсгал шилжүүлэг, 25.7 хувийг бараа ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна. Дүүргийн төсвийн зардал нэмэгдэхэд урсгал шилжүүлгийн зардал голлох нөлөө үзүүлсэн бөгөөд 4 дүгээр сард сангийн яамнаас сургуулийн үдийн хоолны төсөв татсантай холбоотойгоор зардал нэмэгдсэн байна.

Зураг 8. Төсвийн нийт орлого, зарлага, сая төгрөг



³ Төсвийн орлого, зарлагыг Зураг 8-д 2020 оны 2 сард эхний 1,2 сарын гүйцэтгэлийг өссөн дүнгээр оруулсан.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ


2020 оны 5 дугаар сард хэрэглээний үнийн индекс 2019 оны мөн үетэй харьцуулахад 3.5 хувиар өссөн ба 2019 оны эцэстэй харьцуулахад 2.6 хувиар өссөн ба өмнөх сартай харьцуулахад 0.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 17. Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр


Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2020 V</u> 2019 V	<u>2020 V</u> 2019 XII	<u>2020 V</u> 2020 IV
Ерөнхий индекс	103.5	102.6	99.9
Хүнсний бараа, ундаа ус	105.7	110.7	101.1
Согтууруулах ундаа, тамхи	105.3	104.2	100.2
Хувцас, гутал, бөс бараа	105.5	100.7	100.2
Орон сууц, ус, түлш, цахилгаан	104.9	101.1	100.3
Гэр ахуйн бараа, тавилга	103.0	100.7	100.6
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	103.1	101.6	100.2
Тээвэр	91.8	93.1	95.6
Холбооны үйлчилгээ	100.2	100.1	100.0
Амралт чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	113.2	99.7	100.0
Боловсрол	107.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	109.2	103.7	100.7
Бусад бараа, үйлчилгээ	104.3	100.9	100.3

Хэрэглээний үнийн индекс 2020 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 5.7 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 5.3 хувь, хувцас, гутал, бөс барааны бүлгийн үнэ 5.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 4.9 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 3.0 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 3.1 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 13.2 хувь, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ 7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ 9.2 хувь ба бусад бараа үйлчилгээний үнэ 4.3 хувиар өссөн ба тээврийн үнэ 8.2 хувиар буурсан нь нөлөөлжээ.

Зураг 9. Хүнсний ногооны дундаж үнэ, төрлөөр, 2019, 2020 оны V сард



Зураг 10. Махны үнэ, төрлөөр, төгрөгөөр



Хүснэгт 18. Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаалагдаж буй түлш, шатахууны үнэ

Үзүүлэлт	2018 V	2019 V	2020 V
	төгрөг		
Түлш:			
Хар мод	3 500	4 500	4 000
Нарс	3 500	4 000	3 500
Боловсруулсан нүүрс (шуудай)	-	-	3 750
Шатахуун:			
АИ-95	2 050	2 290	1 800
АИ-76, 80	1 480	1 690	1 350
АИ-92, 93	1 630	1 860	1 400
Дизельтүлш	1 720	2 370	1 890
Газ	1 150	1 300	1 300

Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоол ТҮҮХИЙ НҮҮРС ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ хуулийн дагуу 5 дугаар сарын 15ны өдрөөс нүүрс борлуулахыг хориглосон.

Хүснэгт 19. Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үнэ, оноор

Нэр, төрөл	Хэмжих нэгж	2016 V	2017 V	2018 V	2019 V	2020 V
		төгрөг				
Гурил, дээд зэрэг, “Алтан тариа”ХК	кг	1 300	1 237	1 354	1 438	1 456
Гурил, 1-р зэрэг, “Алтан тариа” ХК, задгай	кг	1 150	1 007	1 050	1 094	1 160
Гурил, 2-р зэрэг, “Алтан тариа” ХК	кг	900	846	842	862	890
Талх, “Атар”, “Талх чихэр	кг	1 150	1 207	1 220	1 272	1 274
Цагаан будаа, кг, задгай	кг	3 200	3 300	3 497	3 537	3 840
Шар будаа	кг	1 600	1 500	2 042	2 315	2 283
Хонины мах	кг	6 500	6 890	7 280	9 688	9 840
Үхрийн мах	кг	8 400	7 733	9 300	11 606	12 656
Адууны мах	кг	6 000	5 500	7 250	10 000	10 750
Сүү, задгай	литр	1 500	1 400	7 866	1 840	1 840
Сүү, савласан, “Элекстер”	0.5 литр	960	1 067	1 110	1 130	1 174
Төмс, дотоод	кг	1 000	713	1 446	1 146	930
Лууван, дотоод	кг	2 000	752	2 734	1 456	1 746
Манжин, дотоод	кг	2 000	1 800	3 460	1 794	1 743
Байцаа, дотоод	кг	2 500	1 720	2 054	2 286	1 994
Сонгино, хятад	кг	1 500	1 332	1 694	2 040	1 556
Элсэн чихэр, ОХУ	кг	2 150	2 700	3 103	3 146	3 072
Өндөг	ширхэг	280	345	355	365	365



АЖ ҮЙЛДВЭР

Дүүргийн аж үйлдвэрийн салбар нь 2020 оны эхний 5 сард 290.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 325.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал үйлдвэрлэлт 194.2 тэрбум төгрөгөөр (40.1%), борлуулалт 220.2 тэрбум төгрөгөөр (40.3%) тус тус

буурсан байна.

Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 93.1 тэрбум төгрөгийг (32.1%) уул уурхайн салбарын чулуун нүүрс болон хайлуур жонш, хайлуур жоншны баяжмал, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал, алт, элс, хайрга, шороо үйлдвэрлэл, 131.6 тэрбум төгрөгийг (45.4 %) хүнс ундаа, 39.6 тэрбум төгрөгийг (13.7%) хувцас, гутал, нэхмэл, ноос, ноолуур боловсруулах болон бусад боловсруулах үйлдвэрлэлт үлдсэн 25.8 тэрбум төгрөгийг (8.8%) дулаан үйлдвэрлэлт, усан хангамж эзэлж байна.

Зураг 11. Аж үйлдвэрийн 2019-2020 оны үйлдвэрлэлт, борлуулалт, тэрбум төгрөг



Боловсруулах аж үйлдвэрийн салбарын бууралтанд хүнсний үйлдвэрлэлт, нэхмэлийн үйлдвэрлэлт, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл, мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад, цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэл, ус ариутгал, усан хангамжийн үйлдвэрлэлт нөлөө үзүүлсэн байна.

Хүснэгт 20. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, салбараар, оны үнээр

Салбар	Нийт үйлдвэрлэлт		
	2019 V	2020 V	Өсөлт бууралт
	сая төгрөг		
Нийт дүн	484 317.8	290 113.1	-194 204.7
Уул уурхай олборлох үйлдвэр	250 419.2	93 096.5	-157 322.7
Нүүрс олборлолт	231 281.0	73 781.0	-157 500.0
Төмрийн хүдэр олборлолт	8 068.7	4 947.0	-3 121.7
Бусад ашигт малтмал олборлолт	11 069.5	14 368.5	3 298.9
Боловсруулах үйлдвэр	209 600.9	171 226.3	-38 374.6
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	118 187.8	131 589.8	13 402.0
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	9 951.7	19 361.1	9 409.4
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	29.0	0.0	- 29.0
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6 623.5	4 652.7	-1 970.8
Ундаа үйлдвэрлэл	101 583.6	107 576.0	5 992.4
Нэхмэлийн үйлдвэрлэл	80 767.1	25 608.6	-55 158.5
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	386.1	119.7	- 266.4
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	352.6	255.9	- 96.7
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1 489.2	1 212.0	- 277.2
Нийтлэх, хэвлэх, дүү бичлэг хийх ажиллагаа	61.6	82.9	21.3
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	180.9	7 748.7	7 567.8
Резинен болон хуванцар бүтээгдэхүүн	3 682.2	2 130.0	-1 552.2
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	687.7	267.3	- 420.5
Төмрийн үйлдвэрлэл	44.4	27.2	- 17.1
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	205.1	128.1	- 77.0
Цахилгаан машин, хэрэгсэл үйлдвэрлэл	-	43.7	43.7
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	3 556.3	2 012.5	-1 543.8
Цахилгаан, дулаан, усан хангамж	24 297.7	25 790.3	1 492.6
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэл	1 060.2	1 243.5	183.3
Ус ариутгал, усан хангамж	23 237.5	24 546.9	1 309.3

Хүснэгт 21. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт, салбараар, оны үнээр

Салбар	Нийт борлуулалт		
	2019 V	2020 V	Өсөлт бууралт
	сая төгрөг		
Нийт дүн	545 319.9	325 141.0	-220 178.9
Уул уурхай олборлох үйлдвэр	258 549.7	89 484.0	-169 065.6
Нүүрс олборлолт	231 695.5	73 781.0	-157 914.5
Төмрийн хүдэр олборлолт	8 068.7	4 947.0	-3 121.7
Бусад ашигт малтмал олборлолт	18 785.5	10 756.0	-8 029.5
Боловсруулах үйлдвэр	261 548.6	208 937.4	-52 611.2
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	169 420.8	171 736.4	2 315.6
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	31 931.7	20 806.8	-11 124.9
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	29.0	0.0	- 29.0
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	7 706.8	6 459.0	-1 247.9
Ундаа үйлдвэрлэл	129 753.3	144 470.6	14 717.3
Нэхмэлийн үйлдвэрлэл	80 767.1	25 608.6	-55 158.5
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	385.7	119.8	- 266.0
Арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	298.3	189.6	- 108.7
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1 487.2	1 224.8	- 262.4
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	65.9	70.3	4.5
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	180.9	5 430.9	5 250.0
Резинен болон хуванцар бүтээгдэхүүн	3 702.2	2 130.0	-1 572.2
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	710.7	272.1	- 438.6
Төмрийн үйлдвэрлэл	44.4	27.2	- 17.1
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	205.1	128.1	- 77.0
Цахилгаан машин, хэрэгсэл үйлдвэрлэл	-	17.9	17.9
Мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	4 280.4	1 981.6	-2 298.8
Цахилгаан, дулаан, усан хангамж	25 221.6	26 719.5	1 497.9
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэл	1 056.8	1 153.0	96.2
Ус ариутгал, усан хангамж	24 164.8	25 566.5	1 401.7



МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТАД

Том малын зүй бус хорогдол: Энэ оны эхний 5 сард нийт 10153 хээлтэгч мал төллөсөнөөс 10153 төл гарч 503 төл хорогдож 9650 төл бойжсон байна. Оны эхний 5 сард нийт 328 том мал хорогдож 140 хээлтэгч том мал хорогдсон байна.


ХҮСНЭГТ 22. МАЛ ТӨЛЛӨЛТ, ТӨЛ БОЙЖИЛТЫН МЭДЭЭ, эхний 5 сард

Үзүүлэлт	Бүгд	Үүнээс			
		Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
Төллөсөн хээлтэгч	10153	543	1973	4371	3266
Гарсан төл	10153	543	1973	4371	3266
Хорогдсон төл	503	100	88	145	170
Бойжсон төл	9650	443	1885	4226	3096

ХҮСНЭГТ 23. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДЛЫН МЭДЭЭ, эхний 5 сард

Үзүүлэлт	Бүгд	Үүнээс			
		Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Хорогдсон том мал, бүгд	328	36	76	86	130
Үүнээс: Өвчнөөр хорогдсон	0	0	0	0	0
Хорогдсон хээлтэгч	140	11	21	48	60

ЗУРАГ 12. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДЛЫН МЭДЭЭ



WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах
ТОГЛОМ 

Валютын ханш 



©2017

аппликейшнаас
СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Data lab

тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network




www.facebook.com/StatisticMongolia/




www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn

Утас: 267349, 261019, 261728
E-mail: bayanzurkh@nso.mn